Сувилагч нарын сэтгэл зүйд нөлөөлөх хүчин зүйлс

(ӨМӨЗО-ы Олон улсын Монгол эмнэлгийн жишээ дээр)

Бай Ювэ Лиан (Yue Liang Bai)[1,4], Г. Намуун[2], С.Дэлгэрмаа[3], Г.Ганхуяг[1]

[1]АШУҮИС, СС, Суурь сувилахуйн тэнхим
[2]АШУҮИС, СС, Бие бялдар судлалын тэнхим
[3]АШУҮИС, СС, Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхим
[4]БНХАУ, ӨМӨЗО, Олон улсын Монгол эмнэлэг
Цахим шуудан: gnu24e008@gt.mnums.edu.mn, Утас: 99713004

Түлхүүр үг:
Сэтгэлзүй
Амьдралын чанар
Нөлөөлөх хүчин зүйлс

Товч утга:
Үндэслэл: Сувилагч нь өндөр ачаалалтай орчинд ажилладаг бөгөөд 40% нь дунд ба түүнээс дээш түвшний стресстэй, сэтгэл түгшүүр, сэтгэл гутралын түвшин ерөнхий хүн амаас өндөр байгааг судлаачид тогтоосон байна. ДЭМБ-ын 2020 оны мэдээллээр сувилагч нарын сэтгэл гутрал, түгшүүрийн тохиолдол энгийн хүн амаас 2-3 дахин их байна. **Зорилго:** Сувилагч нарын сэтгэл зүйн байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох. **Арга, аргачлал:** Нэг агшны судалгааны загварыг ашиглан, ӨМӨЗО-ы Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн 262 сувилагч нараас асуумж судалгаа авсан. Хүн амзүйн болон нийгмийн хүчин зүйлийн ерөнхий асуумж 18, WHOQOL-BREF амьдралын чанарын 26 асуумж, Сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хэмжүүр бүхий 21 зүйл (DASS-21), нийт 65 асуумжаар судалгаа авсан. Судалгааг SPSS-29.0 программыг ашиглан өгөгдөлд статистик дүн шинжилгээ хийсэн. **Үр дүн:** Судалгаанд нийт оролцогчдын амьдралын чанарын бие махбодын үзүүлэлт 50.5±7.8 оноо, сэтгэлзүйн үзүүлэлт 54.1±8.7 оноо, нийгмийн хүчин зүйл 58.2±10.5 оноо, орчны үзүүлэлт 52.3±10.4 оноотой байна. Сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хувьд, тус бүр 9.0±8.8 оноо, 9.3±8.6 оноо, 11.9±9.2 оноо байлаа. Сувилагч нарын сэтгэл гутрал, түгшүүр, стресс болон амьдралын чанар хоорондын хамаарал ач холбогдол бүхий урвуу хамааралтай байна ($p<0.01$). Сувилагч нарын нас, ажилласан жил, хүүхдийн тоо, нэг сувилагчид хамаарах тасгийн орны тоо, шөнө унтах цаг зэрэг сэтгэл гутрал, түгшүүр, стрессийг нэмэгдүүлж байна ($p<0.05$). **Дүгнэлт:** 1. Сувилагч нарын сэтгэл гутрал, түгшүүр, стресс зэрэг сэтгэлзүйн үзүүлэлт нь амьдралын чанарыг бууруулж байна. 2. сувилагч нарын нас, ажилласан жил, хүүхдийн тоо, өдрийн ээлжийн хүний тоо, өдөрт амрах хугацаа зэрэг нь сэтгэл зүйд нөлөөлөх хүчин зүйлс болж байна.

Үндэслэл: Орчин үед амьдралын хэмнэл хурдасч, ажлын ачаалал нэмэгдэхийн хэрээр олон хүмүүс сэтгэлийн түгшүүр, гутралд орж байна. Энэ нь сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгийн нэг[1] бөгөөд дэлхийн нийт хүн амын 4.4% нь сэтгэл гутрал, 3.6% нь айдас түгшүүрийн эмгэгтэй гэж тодорхойлогдсон байна.[2]

ДЭМБ-ын мэдээлснээр 2020 оны байдлаар сувилагч нарын сэтгэл гутрал, түгшүүрийн тохиолдол энгийн хүн амаас 2-3 дахин их байна.[3] Сувилагчдын сэтгэлзүйн байдал нь өөрсдийнх нь эрүүл мэндэд нөлөөлөөд зогсохгүй, эмнэлгийн орчинд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарт нөлөөлдөг. Тухайлбал, хүнд хэлбэрийн сэтгэл гутралтай сувилагчдын сувилахуйн тусламж үйлчилгээний алдааны эрсдэл 3 дахин нэмэгддэг байна.[4]

Сувилагч нь эмчлүүлэгчдийн эрүүл мэнд, асаргаа сувилгааг хариуцах зэрэг ажлын байран дээрх ачаалал өндөр байх нь стресс үүсгэгч хүчин зүйл болдог байна.[5] Сувилагчдын стрессийн түвшин дундаас өндөр түвшинд хэлбэлздэг бөгөөд тархалтын хувь нь 40-90% гэж судлаачид тогтоосон байна.[6] Америкийн Сэтгэцийн Эмгэг Судлалын Холбоо (APA)-ны тодорхойлсноор түгшүүр нь ирээдүйд болох сөрөг үйл явдал эсвэл аюултай нөхцөл байдлыг урьдчилан төсөөлөх, дагалдах сэтгэл санаа болон биемахбодын

тавгүй байдлын мэдрэмж юм.[7] Сувилагчдын түгшүүрт нөлөөлдөг хүчин зүйлүүдэд: эмчлүүлэгчийн биеийн байдал гэнэт өөрчлөгдөх, шөнийн ээлж, эмчилгээний тодорхой бус байдал, ажлын хэт ачаалал, заавал хийгдэх илүү цаг, ажлын байрны тогтворгүй байдал, олон талт ажлын орчин болон шинэ орчинд дасан зохицох зэрэг багтана. Эдгээр хүчин зүйл нь сувилагчдын түгшүүрийг нэмэгдүүлж, тэдний эрүүл мэнд болон амьдралын чанарт (QOL) ноцтой хохирол учруулж болзошгүй гэжээ.[8]

Сэтгэл гутрал нь гуниг, сонирхолгүй байдал, амархан уурлах зэрэг шинж тэмдгээр илэрдэг сэтгэл санааны эмгэг юм. Энэ нь хувь хүний үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлөх биемахбод, танин мэдэхүйн өөрчлөлтөөр илэрдэг.[9] Сэтгэл гутралын шинж тэмдгийн тархалт Иран улсын сувилагчдын дунд 1.7-40.9% хүртэл[10], Хятад улсын сувилагчдын дунд 43.83%[11], Австралийн сувилагчдын дунд 32.4% байна.[6] Хятад улсад 2007 оноос 2016 он хүртэл нийт 46 сувилагч амиа хорлосон тохиолдол мэдээллэгдсэн байна.[12] Сувилагчдын сэтгэцийн эрүүл мэнд өөрчлөгдөх нь зөвхөн тэдний сайн сайхан байдалд төдийгүй эмчлүүлэгчдэд үзүүлж буй асаргааны чанарт сөргөөр нөлөөлдөг. Сувилагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийн байдал, нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах нь тэдгээрийн амьдралын чанарыг дээшлүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд тустай.

Судалгаанаас харахад хятад улсын эмнэлгийн сувилагч нарын ажил, амьдралын өнөөгийн чанар дунд түвшинд байгаа бөгөөд сувилагчдын дийлэнх нь ажил, амьдралдаа сэтгэл хангалуун бус байдаг гэсэн байна.[13-18] Иймд сувилагчдын ажил, амьдралын чанарт анхаарч, сайжруулах бодит шаардлага гарч байна.

Зорилго: Сувилагч нарын сэтгэл зүйн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох.

Зорилт:

1. ӨМӨЗО-ы Олон улсын Монгол эмнэлгийн сувилагч нарын сэтгэлзүйн байдал, амьдралын чанарын хамаарлыг тодорхойлох
2. ӨМӨЗО-ы Олон улсын Монгол эмнэлгийн сувилагч нарын сэтгэлзүйн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох

Арга, аргачлал: Бид нэг агшны судалгааны загварыг ашиглан, АШУҮИС-ийн СС болон ӨМӨЗО-ы Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн 262 сувилагч нараас 2024 оны 7-р сарын 1-ээс 2024 оны 10-р сарын 1-ний хооронд асуумж судалгаа авсан. Эмнэлгийн холбогдох албад болон судалгаанд хамрагдагсдаас зөвшөөрөл авсны дараа асуумж авсан. Нийт судалгаанд оролцогчдоос 3 бүлэг асуумж авч мэдээллийг цуглуулсан. Үүнд: Хүн ам зүйн болон нийгмийн хүчин зүйлийн ерөнхий 18 асуумж, WHOQOL- амьдралын чанарын 26 асуумж[19], Сэтгэл гутрал, түгшүүр, стрессийн хэмжүүр бүхий 21 зүйл (DASS-21) асуумж. Судалгааны ёс зүйн зөвшөөрлийг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024.05.17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж (2024/3-05) судалгаа хийх зөвшөөрөл авсан. Мөн ӨМӨЗО-ы Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн Ёс зүйн хорооны 2024.05.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж (2024-19) зөвшөөрөл авсан.

Статистик боловсруулалт: Тоон утгыг дундаж болон стандарт хазайлтаар, категорик утгыг тоо, хувиар илэрхийлсэн. Асуумжийн найдвартай байдлыг Кронбах альфагаар тодорхойлсны дараа үр дүнг тооцоолсон. Хэвийн хазайлтыг тодорхойлсны дараа хамаарал хоорондын утгыг спийрманы корреляцаар тооцсон. SPSS-29.0 программыг ашиглан өгөгдөлд статистик дүн шинжилгээ хийсэн. P утга <0.05 тохиолдолд статистик ач холбогдолтой гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд нийт оролцогчдын дундаж нас 32.65±4.75 жил эдгээрээс 52.3% нь арваас дээш жил ажилласан, 88.9% бакалаврын зэрэгтэй, нэг тасгийн орны тоо дунджаар 55.7±20.0, өдрийн ээлжинд тусламж үйлчилгээ үзүүлдэг хүний тоо дунджаар 26.8±19.1 байлаа. Сувилагч нарын амьдралын чанарын үзүүлэлтийг биемахбод, сэтгэлзүй, нийгмийн хүчин зүйл, орчны хүчин зүйл гэсэн үзүүлэлтийг харахад тус бүр 50.5±7.8 оноо, 54.1±8.7 оноо, 58.2±10.5 оноо, болон 52.3±10.4 оноо байна. Сэтгэл гутралын үзүүлэлт 9.0±8.8 оноо, сэтгэл түгшүүр 9.3±8.6 оноо, стресс 11.9±9.2 оноо байлаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт	Утга
Нас, жилээр	32.65±4.75
Хүйс	
Эмэгтэй, n (%)	234 (89.3)
Эрэгтэй, n (%)	28 (10.7)
Боловсрол	
Диплом, n (%)	28 (10.7)
Бакалавр, n (%)	233 (88.9)
Магистр, n (%)	1 (0.4)
Ажилласан жил	
5 хүртэл, n (%)	51 (19.5)
5-10 жил, n (%)	74 (28.2)
10-аас дээш, n (%)	137 (52.3)
Тасгийн орны тоо	55.7±20.0
Өдөрт унтах цаг	6.32±1.04
Өдрийн ээлжинд үйлчлүүлдэг эмчлүүлэгчдийн тоо	26.8±19.1
Сэтгэлзүй, оноогоор	
Сэтгэл гутрал	9.0±8.8
Сэтгэл түгшүүр	9.3±8.6
Стресс	11.9±9.2
Амьдралын чанар, оноогоор	
Биемахбодын үзүүлэлт	50.5±7.8
Сэтгэлзүйн үзүүлэлт	54.1±8.7
Нийгмийн хүчин зүйл	58.2±10.5
Орчны хүчин зүйл	52.3±10.4

Тайлбар: *Товч утга, n (%), тоо (хувь);*
Тоон утга дундаж, стандарт хазайлтаар илэрхийлэв;
Категорик утгыг тоо, хувиар илэрхийлэв;

Сувилагч нарын сэтгэл гутрал, түгшүүр, стресс болон амьдралын чанар хоорондын хамаарал ач холбогдол бүхий урвуу хамааралтай байна (p<0.01). Өөрөөр хэлбэл, сувилагч нарын сэтгэлзүйн үзүүлэлт буурах тусам амьдралын чанар буурч байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Сэтгэлзүй, амьдралын чанар хоорондын хамаарал (n=262)

Үзүүлэлт	Сэтгэл гутрал	Түгшүүр	Стресс
Биемахбодын хүчин зүйл	-0.287**	-0.202**	-0.288**
Сэтгэлзүй	-0.495**	-0.406**	-0.466**
Нийгмийн хүчин зүйл	-0.449**	-0.408**	-0.472**
Орчны хүчин зүйл	-0.524**	-0.478**	-0.519**

Тайлбар: **p<0.05; **p<0.01*

Сувилагч нарын нас, ажилласан жил нэмэгдэх тусам сэтгэл гутрал, түгшүүр, стрессийг нэмэгдүүлж байна (p<0.05). Харин хүүхдийн тоо их байх нь стрессийг ихэсгэж байгаа (p<0.05) бол өдөрт унтаж амрах цаг буурах тусам сэтгэлзүйн үзүүлэлт статистик ач холбогдол бүхий буурч байна (p<0.05) (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Сувилагч нарын сэтгэлзүйн үзүүлэлтэнд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарал

Үзүүлэлт	Сэтгэл гутрал	Түгшүүр	Стресс
Нас, жилээр	0.171**	0.154*	0.219**
Хүүхдийн тоо	0.111	0.088	0.126*
Ажилласан жил	0.159*	0.157*	0.179**
Унтах цаг	-0.205**	-0.126*	-0.169**
Тасгийн ор	-0.054	-0.044	0.003
Өдрийн ээлжийн эмчлүүлэгчийн тоо	0.038	0.112	0.106
Шөнийн ээлжийн эмчлүүлэгчийн тоо	-0.066	-0.111	-0.043

Тайлбар*: *p<0.05; **p<0.01*

Хэлцэмж: Энэхүү судалгаа нь ӨМӨЗО-ы Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн сувилагч нарын дунд явуулсан асуумж судалгаанд үндэслэн, тэдний сэтгэлзүйн эрүүл мэнд (сэтгэл гутрал, түгшүүр, стресс) болон амьдралын чанарын хоорондын хамаарлыг системтэйгээр шинжилж, эдгээр хүчин зүйлсэд нөлөөлж буй хувь хүн болон ажлын орчны нөлөөллийг тодорхойлсон. Судалгааны үр дүнгээс харахад сувилагч нарын дунд сэтгэлзүйн сөрөг байдлын түвшин өндөр, амьдралын чанар дунд ба доогуур түвшинд байгаа бөгөөд сэтгэлзүй ба амьдралын чанарын хооронд статистикийн хувьд ач холбогдол бүхий урвуу хамаарал (p<0.01) илэрсэн. Энэ нь өмнөх судалгааг бататган, сувилагчдын сэтгэлзүйн дэмжлэг ба ажлын орчныг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Сэтгэлзүйн нийт түвшинг авч үзвэл, бүгд DASS-21 асуумжийн “Дунд зэрэг” ангиллын доод хязгаарт дөхөж байгаа ч ноцтой түвшинд хүрээгүй байна. Энэ нь гуравдугаар шатлалын эмнэлэгт ажиллаж буй сувилагчдын хувьд ажлын ачаалал их, хурдтай орчин, мэргэжлийн эрсдэл зэргээс шалтгаалан өндөр үзүүлэлттэй байгаа нь үндэслэлтэй. Maharaj S (2018), Chand SP (2025), Isfahani P (2022) нарын судлаачдын сувилагчдын дунд хийсэн судалгааны үр дүнтэй ойролцоо болон дүйж байна.[6,9,10]

Амьдралын чанарын дөрвөн хүчин зүйлийг харьцуулахад нийгмийн үзүүлэлт өндөр, бие махбодын үзүүлэлт бага оноотой байсан нь сувилагчдын биеийн эрүүл мэнд илүү их сорилттой тулгарч буйг харуулж байна. Мөн сэтгэл гутрал, түгшүүр, стресс нь амьдралын чанарын бүх үзүүлэлттэй урвуу хамааралтай байгаа нь (p<0.001) сэтгэлзүйн байдал нь амьдралын чанарын чухал тодорхойлогч болохыг илэрхийлсэн Ma Wenjuan (2013) нарын судалгаатай дүйж байна.[20]

Нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээгээр сувилагчийн нас, ажилласан жил, хүүхдийн тоо, өдөрт амрах цаг зэрэг нь сэтгэлзүйн үзүүлэлттэй эерэг хамааралтай, амьдралын чанарыг бууруулж байна (p<0.05). Энэ нь Ma Wenjuan (2013) нарын “Ажлын дарамт амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөг» гэсэн дүгнэлтийг баталж, ажлын жил нэмэгдэхийн хэрээр хариуцлага, ачаалал нэмэгдэж буйг харуулж байна.[20]

Мөн шөнө ээлж хийх, сэтгэл хөдлөлийн хөдөлмөр, өндөр хариуцлага, мэргэжлийн эрсдэл зэрэг сувилагчийн ажил мэргэжлээс шалтгаалах архаг дарамтууд нь сэтгэлзүйн тогтвортой байдлыг алдагдуулж, урт хугацааны сөрөг сэтгэлзүйн эмгэгийг үүсгэх шалтгаан болдог. Иймд сэтгэлзүйн сургалт, уян хатан ээлжийн зохион байгуулалт, стресс бууруулах хөтөлбөр, мэргэжлийн сүлжээ зэргийг багтаасан системтэй менежментийн арга хэмжээ хэрэгтэй байна. Хэдийгээр энэхүү судалгаа нь төлөөлөх чадвартай, WHOQOL-BREF болон DASS-21 зэрэг олон улсын стандартад нийцсэн асуумж ашигласан нь арга зүйн хувьд найдвартай гэж үзэж болох ч нэг агшингийн шинж чанартай тул шалтгаан-хамаарлын дүгнэлт хийх боломж хязгаарлагдмал юм. Мөн нэг эмнэлгийн мэдээлэлд тулгуурласан тул үр дүнг өргөн хүрээнд хэрэглэхэд болгоомжтой хандах шаардлагатай.

Дүгнэж хэлбэл, энэхүү судалгаа нь эмнэлгийн орчин дахь сувилагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийн эрсдэл, амьдралын чанарын бууралтыг харуулж, түүний цаадах хувь хүн болон ажлын орчны нөлөөллийг тодорхойлсон. Судалгааны үр дүн нь сувилагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийг хамгаалах бодлогыг боловсруулж, эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Дүгнэлт:

1. Сувилагч нарын сэтгэл гутрал, түгшүүр, стресс зэрэг сэтгэлзүйн үзүүлэлт нь амьдралын чанарыг бууруулж байна.
2. Сувилагч нарын нас, ажилласан жил, хүүхдийн тоо, өдрийн ээлжийн хүний тоо, өдөрт амрах хугацаа зэрэг нь сэтгэл зүйд нөлөөлөх хүчин зүйлс болж байна.

Ном зүй:

1. *Ferrari AJ, Somerville AJ, Baxter AJ, et al. Global variation in the prevalence and incidence of major depressive disorder: a systematic review of the epidemiological literature. Psychological medicine. 2013;43(3):471-481.*
2. *WHO. Depression and other mental health disorders. Global Health Estimates. 2017; https://www.who.int/publications/i/item/depression-global-health-estimates.*
3. *WHO. State of the world's nursing 2020: investing in education, jobs and leadership. 2020; https://www.who.int/publications/i/item/9789240003279.*
4. *Hall LH, Johnson J, Watt I, Tsipa A, O'Connor DB. Healthcare Staff Wellbeing, Burnout, and Patient Safety: A Systematic Review. PLOS ONE. 2016;11(7):e0159015.*
5. *Mohammadi M, Vaisi-Raygani A, Jalali R, Salari N. Prevalence of job stress in nurses working in Iranian hospitals: a systematic review, meta-analysis and meta-regression study. JHSW. 2020;10(2):119-128.*
6. *Maharaj S, Lees T, Lal S. Prevalence and Risk Factors of Depression, Anxiety, and Stress in a Cohort of Australian Nurses. International journal of environmental research and public health. 2018;16(1).*
7. *Perrotta G. Anxiety Disorders: Definitions, Contexts, Neural Correlates And Strategic Therapy. 2019;6:15.*
8. *Vafaee-Najar A, Houshmand E, Esmaily H, Ashrafnezhad F. Obvious and hidden anxiety and quality of working life among nurses in educational hospitals. Payesh (Health Monitor). 2015;14(5):565-576.*
9. *Chand SP, Arif H, Kutlenios RM. Depression (Nursing). In: StatPearls. Treasure Island (FL) ineligible companies. 2025.*
10. *Isfahani P, Bahador RC, Peirovy S, Afshari M, Samani S. Prevalence of depression among nurses of Iran: A meta-analysis. Evidence Based Health Policy, Management and Economics. 2022.*
11. *Xie N, Qin Y, Wang T, Zeng Y, Deng X, Guan L. Prevalence of depressive symptoms among nurses in China: a systematic review and meta-analysis. PloS one. 2020;15(7):e0235448.*
12. *Zeng HJ, Zhou GY, Yan HH, Yang XH, Jin HM. Chinese nurses are at high risk for suicide: A review of nurses suicide in China 2007–2016. Archives of psychiatric nursing. 2018;32(6):896-900.*
13. *Xin F. Correlation between nurses' occupational resilience, professional identity and quality of work life. Changchun University of Traditional Chinese Medicine. 2021.*
14. *Yan Z. Correlation analysis between psychological resilience and quality of work life of ICU nurses in tertiary hospitals. Zhangqiao Scientific Research. 2020.*
15. *Hu Shanshan LJ, Jiang Panhua, Gu Ying. Investigation on the current status of work and life quality of obstetric nurses in Wuxi and analysis of influencing factors. Occupation and Health. 2021;37(19):2632-2642.*
16. *Tu Shuhan GH, Zhu Yun, Xie Xiujuan. Research on the impact of oncology nurses' sense of life meaning on work-life quality. Nursing Research. 2022;36(08):1395-1399.*
17. *Li Zijing YY, Zhang Yimin, et al. Study on the current status and correlation between psychological capital and work-related quality of life of nurses in the emergency department of tertiary hospitals. Occupational Health and Emergency Rescue. 2022;40(02):175-179.*
18. *Zhang Jianhong YQ. Study on the correlation between organizational support and work-life quality of interventional operating room nurses. Everyone's Health. 2022;13:108-110.*
19. *WHO. The World Health Organization quality of life (WHOQOL) - BREF. Geneva: World Health Organization; 2004 2004.*
20. *Ma Wenjuan YY, Zhou Anan, et al. Study on the correlation between nurses' work stress and quality of life. Journal of Traditional Chinese Medicine Hospital Management. 2013;33(1):75-77.*

Factors influencing nurse's psychology

(The example of the International Mongolia hospital in the Inner Mongolia)

Yue Lian Bai[1,4], Namuun G[2], Delgermaa S[3], Gankhuyag G[1]

[1]Department of Fundamentals Nursing, School of Nursing, MNUMS
[2]Department of Physical and Occupational therapy, School of Nursing, MNUMS
[3]Department of Adult Nursing, School of Nursing, MNUMS
[4]International Mongolia Hospital, Inner Mongolia, China
E-mail: gnu24e008@gt.mnums.edu.mn, Tel: +976-99713004

Background: Nurses work in a high-stress environment, with 40% experiencing moderate or higher levels of stress and higher levels of anxiety and depression than the general population. According to WHO 2020 data, the incidence of depression and anxiety among nurses is 2-3 times higher than that of the general population.
Aim: To identify factors that affect the psychological state of nurses.
Materials and Methods: Using a cross sectional study design, a questionnaire was administered to 262 nurses at the International Mongolian Hospital in Hohhot, Inner Mongolia Autonomous Region. The survey was conducted using 18 general demographic and social factor questionnaires, 26 WHOQOL-BREF quality of life questionnaires, and 21 items with a scale of depression, anxiety, and stress (DASS-21), a total of 65 questionnaires. The study was conducted using SPSS 29.0 software to statistically analyze the data.
Results: The physical domain of quality of life score of the study participants was 50.5±7.8, psychological domain of quality of life score was 54.1±8.7, social domain factor's score was 58.2±10.5, and environmental factor's score was 52.3±10.4. Depression, anxiety, and stress's score were 9.0±8.8, 9.3±8.6, and 11.9±9.2, respectively. The relationship between nurse's depression, anxiety, and stress and quality of life was significantly inversely correlated ($p<0.01$). Nurse's age, working years, number of children, number of beds per ward per nurse, and hours of sleep at night increased depression, anxiety, and stress ($p<0.05$).
Conclusions:

1. Psychological indicators such as depression, anxiety, and stress among nurses are reducing their quality of life.
2. In addition, factors such as the nurses' age, years of service, number of children, number of people on a daily shift, and sleep time per day are also factors that affect psychological well-being.

Keywords: Psychology, Quality of life, Influencing factors